

ГЕРМАНЫ ЭРДЭМТЭД ТӨВ АЗИЙГ ХҮШ-ХХ ЗУУНД СУДАЛСАН НЬ

(Казахстан, Дорнод Туркестан, Монгол судлалын жишээн дээр)

*М.Хурметхан**

Эхлэл нь өмнөх дугаарт

Германы түрэг судлаачид

Эртний түрэг бичээсийг тайлж уншсаны дараа, өрнөдийн орнууд, түүний дотор Германы түрэг судлаачид ихээхэн анхааран судлах болов. Тус салбарт А.фон Ле Кок, И.Маркварт, Ф.В.К.Мюллер, В.Банг нарын бүтээл гарчээ.

- А.фон Ле Кок /Albert von Le Coq 1860- Берлин, 1930/ германы алдарт дорнодахин судлаач, турколог. А.фон Ле Кок Берлин хотын Дорнодахины хэлний Семинар болон Этнографийн музейн Африк болон Океанолгийн секцид суралцжээ. Тэрээр Төв Азийн эртний соёл иргеншилийг судлахаар 1902-1903, 1904-1907, 1908-1912, 1913-1914 онуудад Дорнод Туркестанд зохион байгуулагдсан Германы 4 удаагийн экспедицид оролцов. Энэхүү судалгааны материалыг үндэслэн эртний бичээс, дурсгалууд, соёлын өвийн талаар “Урлагийн талаархи зургийн атлас болон Төв Азийн урлагийн түүх”, Берлин 1925, “Хотаны түрэгийн манихейка” т.1-3. Берлин, 1912-1923, г.м бүтээл турвижээ. Ле Кокын “Дорнод Туркестан ба түүний ард түмэн” Лейпциг 1928, “Дорнод Туркестан дахь Элладагийн мөрөөр” Лейпциг, 1926 хэмээх бүтээлүүдэд орон нутгийн ард түмний хэл ба ардын соёл болон эллинизмын өөр хоорондын харилцааны тухай өгүүлжээ.

- Маркварт Йозеф /Markbart, Margnart, Josef 1864-1830/ Германы дорнодахин судлаач эрдэмтэн юм. 1902 оноос Этнографийн музейн хадгалагч, дараа нь Лейдений их сургуулийн профессор болов. 1912 оноос амьдралын эцэс хүртэл Берлинд иран болон армян хэлний профессоор байв. Тэрээр үндсэндээ эртний түрэг хэл, түүх, этнографийг судалжээ. Тэрээр хэд хэдэн хэлийг төгс эзэмшсэн байжээ.

- Миллер Мюллер Ф.В.К /Myller Friedrich Wilhelm Karl/ бол германы нэрт дорнодахин судлаач эрдэмтэн юм.Түүний олон бүтээл нь түрэг судлалын алтан санд оржээ.¹⁷

- Банг-Кауп Вилли /Johann WilhelmMax Julius Bang-Kaup /9.8.1869- Везель, ФРГ, 8.10.1934/ Германы алдарт түрэг судлаач юм. Бельгийн Лувегийн их сургуулийг төгссөн ба 1895-1914 онуудад Лувегийн их сургуулийн англи хэлний профессор байв. Түрэг судлалаар хичээл заах ажлаа 1917 онд Франкфуртэд эхлэв. 1918 оноос насан эцэслэх хүртэл

* М.Хурметхан - ОУСХ-гийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор (Sc.D), профессор

Берлиний их сургуулийн туркологийн профессор байв. Бангийн бүтээлүүд 91 ном болон эрдэм шинжилгээний өгүүлүүд ба 29 шүүмж нь түрэг хэлнүүдийн харцуулсан хэл зүй, руни бичээс, уйгур бичээсийн дурсгалууд, түрэг хэлнүүдийн нутгийн аялгуу, үгсийн сан судлалд зориулагджээ.

- И.Бенцинг /Johannes Benzig/ 1913 Алтай судлалын эрдэмтэн, ХБНГУ-ын Майнзын их сургуулийн туркологийн салбарыг олон жил удирдсан байна. Кигчак болон хүннүгийн хэлний талаар судалгаа хийжээ.¹⁸

- Г.Дёрфер /Gerhard Doerfer, 1920/ Алтайн судлал ба туркологийн нэрт эрдэмтэн Геттигений их сургуулийн туркологи ба алтай судлалын салбарыг удирдаж, хүннү, уйгур хэлний талаар судалгаа хийжээ.¹⁹

- А.фон Габен /Annemarie von Gavain/²⁰ Германы туркологийн нэрт төлөөлөгч эмэгтэй В.Бангийн шавь бөгөөд эртний түрэг хэл, түүх, соёлыг судалсан эрдэмтэн юм.

Германы эрдэмтэд Дорнод Туркестаныг судалсан нь

Төв Ази бол өөрийн байгаль, өөрийн уугуул оршин суугчид тэдний амьд түүх, соёлын ололт зэргээр манай дэлхийн сонирхолтой бүс нутаг билээ.²¹ Хэдий тийм боловч, XIX зууны түүхэн үйл явцын үр дүнд л Төв Ази нь Германы олон нийтийн анхааралд өртсөн байна. Төв Ази судлалын шийдвэрлэх түлхэц нь шинэ шинжлэх ухаан-газар зүй, археологийг үндэслэхтэй холбоотой байв.

Германы хувьд Төв Азийг шинжлэх ухааны үүднээс анхлан судлах нь 1855 онд Адольф Шлагинтвейт /Schlagintweit/-ийн шинэтгэгч үйл ажиллагаанаас авсан байна. Энэ нь Плано Карпини, Гильом Рубрук, Марко Пологийн дараа Төв Азид хийгдсэн томоохон аялал байлаа. Энэ үед Төв Ази дэлхийн шинжлэх ухаанд бүрэн төгс танил биш байлаа. Ялангуяа, Чин гүрэн Тянь-Шань болон Куньлунгийн сүрлэг уулаар хүрээлэгдсэн Дорнод Туркестаныг гадаад ертөнцтэй харилцаатай байхыг эрс хориглож байв.

Европын эрдэмтдийн тус нутагт нэвтэрч судлагаа хийх гэсэн оролдлого нь амжилтгүй, заримдаа гунигтай төгсдөг байжээ. Тухайлбал, 1857 онд Германы нэрт жуулчин, судлаач Адольф Шлагинвейт Кашгар хотод /одоогийн БНХАУ-ын СУАР-ны Кашгар хот/ алагдсан байна.

Казахын нэрт жуулчин, эрдэмтэн Ч.Валиханов 1858 оны X сарын 2-ноос 1859 оны III сарын 11-ний хооронд Кашгар хотод байсан үедээ Адольф Шлагинтвейт /Schlagintweit/ ямар нөхцөлд амь насаа алдсан тухай үнэн мэдээллийг анх олж авчиржээ. Тэр өөрийн “Адольф Шлагинтвейтийг үхэлд хүргэсэн байдлын тухай мэдээлэлд” энэ тухай тодорхой өгүүлсэн юм.²² Түүний дараа Рихтгофен /Richthofen/ Фердинанд Пауль Вильгельм /1883-1905/-ийн газар зүйн судалгааны

ажлууд хийгдэж, тэрээр Азийн орографийн гол шинжүүдийг нээн, леёс давхаргын тухай гипотезийг үндэслэн зохиогч билээ.²³

Дорнод Туркестаны эртний соёлыг судлахад Германы 1902-1904 оны хооронд зохион байгуулагдсан дөрвөн удаагийн шинжилгээний анги ихээхэн үүрэг гүйцэтгэсэн юм. Германы эрдэмтэд Дорнод Туркестаныг судлах ажлаа зохион байгуулахад Оросын эрдэмтдийн туршлагыг ашиглажээ. Тухайлбал, анхны шинжилгээний ангийн удирдагч А.Грюнведель /Albert Grünwedel/ 1899 онд өөрийн боловсруулсан эрдэм шинжилгээний анхны төлөвлөгөө нь Оросын академичууд В.В.Радлов /W.W.Radloff/ К.Г.Залеман /Salemann/ болон Турфанд аялсан жуулчин Д.А.Клеменц /D.A.Klementz/ нар Берлинд ирсэнтэй шууд холбоотойг тэмдэглэсэн байна.²⁴ Берлингийн угсаатны зүйн музейн явуулсан шинжилгээний ангийг А.Грюнведель²⁵ удирдсан байна. А.Грюнведель нь нэрт энэтхэг судлаач, Энэтхэг, Өмнөд Ази, Монгол, Төвдийн бурханы урлагийн томоохон мэргэжилтэн байв. Түүнээс гадна тэрээр төгс сайн уран зураач байсан бөгөөд туургатны асар олон зургийг хуулбарлан зурж, зураг, зураглал хийсэн байна. Германы анхны шинжилгээний ангийн бүрэлдэхүүнд хэл шинжлэлч бөгөөд угсаатны зүйч Г.Хут /G.Hurth/ болон уран зураач Т.Бартус /Th.Bartus/ нар оржээ. Судлаачид Д.А.Клеменцийн дараагаар Турфанд ажиллаж, тэнд 1902 оны 11-р сараас 1903 оны 3-р сар хүртэл нилээд удаан хугацааг өнгөрүүлсэн байна.

Шинжилгээний багийг профессор Альберт Грюнведель удирдан бүрэлдэхүүнд нь доктор Г.Хут болон уран зураач Т.Бартус нар оржээ. Жуулчилах зам нь Курля-Урумчи-Турфаны баянбүрд (Кочо, Бизиклик, Сингим, Тулюкт 1902 оны 11-р сараас 1903 оны 3-р сар) эндээс дүрслэх урлаг, хүн хөшөө, түрэг, тангад, хятад бичээсийн дурсгалууд олсон ба Торгоны замын зүүн салаа –Туксун-Карашар-Куча-Кумтурын балгас-Кизил-Аксу-Тумшук-Маралбашы-Кашгар гэсэн маршрутгаар явжээ. Тэндээс судалгааны явцад 46 хайрцаг олдвор олжээ.

Судалгааны гол анхаарлаа Идикутшарыг /Idikutahri/ судлахад хамруулсан байна. Судлаачид эвдэрхий балгасын дэвсгэр зургийг шинээр хийж эртний энэ хотын тоймчилсон бүтцийн тухай найдвартай төсөөллийг бий болгожээ. Тэрчлэн хадгалагдан үлдсэн 2 байшингийн ханыг тодорхойлон бичсэн байна. Түүнийг туйпуу болон дагширсан шороогоор барьсан 30 гаруй барилгын балгасны дэвсгэр зургийг тэмдэглэн үлдээжээ. Эдгээр нь үндсэндээ бурхны сүм, гишгүүр зэрэг бусад бурханы барилга байгууламж байв. Уран барилгыг судлах талаар германы эрдэмтэд ихээхэн анхаарал хандуулсан хэдий боловч шинжилгээний ангийн бүрэлдэхүүнд мэргэжлийн уран барилгын мэргэжилтэн байгаагүй нь судлаачид үр дүнгийн түвшин доошлоход нөлөөлсөн байна. Тэрчлэн урлагийн бүтээлүүдийг тодорхой судлан,

зургийг нь авч, хуулбарыг нь өнгөтөөр зурж, бичээсүүдийг нягт нямбай тэмдэглэн бичжээ. Нэгэн байшингаас манихейн гар бичмэл олдсон байна. Сенгим-Огуз болон Муртукийн эвдэрхий балгас болон бусад дурсгалыг нарийвчлан судалсан байна.²⁶

А.фон Ле Кок (1860-1930)²⁷-аар удирдуулсан германы хоёр дахь шинжилгээний ангийг бэлтгэн явуулахад тусгайлан байгуулагдсан Турфаны хороо тус дөхөм болж, шинжилгээний ангид шаардлагатай хэрэгсэл цуглуулж, улсаас мөнгөн тусламж үзүүлсэн байна. Уг судалгааны ангийг доктор А.Фон Ле Кок удирдан Т.Бартус оролцжээ. Аяллын зам нь Урумчи-Турфаны баян бүрд болох Кочо, түүний хавь нутаг, Яр-хотод 1904 оны 8-р сараас 1905 оны 8-сар хүртэл, Хамид 1905 оны 8-р сард, Турфан-Торгоны замын зүүн салаа Кашгарт 1905 оны 10-р сард судалгааны ажилаа үргэлжлүүлэв. Энд германы гурав дахь шинжилгээний ангийнхантай уулзав. Энэ удаа 103 хайрцагаас бүрдэх чухал олдвор олсон бөгөөд дүрслэх урлагийн бүтээл, ном судар зэрэг байв. А.фон Ле Кок германы хоёр дахь шинжилгээний ангийг бэлтгэн явуулах замдаа Санкт-Петербуркт ирэхэд түүнд оросын эрдэмтдийн зүгээс тусламж дэмжлэг үзүүлсэн байна. Дорнод Туркестанд хоёр дахь удаагийн Германы шинжилгээний ангийн судалгааны ажил 1904 оны 9 сараас 1905 оны 12 сар хүртэл жил илүү хугацаагаар үргэлжилсэн байна. А.фон Ле Кок Идикутшарыг судлах ажлыг үргэлжлүүлсэн байна. Тэрээр хотын бэхлэлтийг нарийвчлан үзэж, бүх барилгын эвдэрхий туурийг олжээ. Орон нутгийн оршин суугчид тусгай хэвийн тусламжтайгаар бүтээсэн шавар хүн хөшөөний толгойг түүнд авчирч өгчээ. Үүний дараагаар тэд судалгааны багийн гишүүдийг эвдэрхий балгасын төвд барилгын заал гэмээр барилгад дагуулан очсон байна. А.фон Ле Кок түүний нэг хананд туурганы зураг байгааг ажиг мэджээ. Энд ёслолын цагаан хувцас өмсөн хүмүүсийн дунд Мани дүрслэгджээ. Түүний нэрийг согд бичээсээр бичээсээр тус бүрийн цээжинд бичиж байжээ. Энэ олдвор нь урьд өмнө нь манехейчууд өөрсдийн уран зургаар чимэглэсэн тахилын байгууламжгүй байсан гэх төсөөллийг няцаав.²⁸ Харамсалтай нь энэхүү өвөрмөц шашныг судлахад үнэ цэнэтэй хэрэглэгдэхүүн болох манехейн бичээсийн ихэнх хэсэг нь шинжилгээний анги ирэхээс өмнө устсан байна. Мөн эртний бичмэлийн хэсгийг эрж олох боломж ч олджээ. Эртний бичмэлийг цаас, зөөлөн арьс болон торгонд бичсэн хэсгүүд болон арьсыг алтаар өнгөлөн хээ даран гаргасан хавтастайгаар олдсон байна. Ялангуяа мэлхий хуягийг нарийн өнгөлөн алтаар гадарласан номын хавтасны хэлтэрхий нь бусдаас гойд сайнаар ялгаран байжээ. Манехейн эртний бичмэлүүд нь хичээнгүй бичгийн уран чадвараар товойн харагдсан байна. Шинжилгээний ангийнхан өөр нэг байшингаас усанд гэмтсэн

эртний бичмэлүүдийг олон тоогоор олж авчээ. Тэдгээр нь өөр хоорондоо нийлэн нягтран нэгдсэн лааглагдсан эд болжээ. Зөвхөн хурц өнгийн будгаар өнгөлсөн цөөн тооны бичмэл, бяцхан уран зургийн хэсгийг аврах бололцоо олдсон байна. Тэрчлэн барилгын ханын зургууд олдсон хэдий ч мөн усанд гэмтсэн байна. Нарийн хонгилд гар бичмэл хадгалах газрын орчимд олон тооны даавууны тасархай хэсгүүд олдсон бөгөөд тэдгээрийн зурсан зургуудад манехейн лам хуварга хүмүүсийг дүрсэлжээ.²⁹

Тэрчлэн эрдэмтэн дөрвөн барилгаас бүрдэх бөмбөгөр оройтой цогцолборыг судалсан байна. Тэдний нэгнээс эмх замбраагүй овоолон хаясан хатсан хүний яс хэдэн зуун байгааг олжээ. Өмссөн хувцасаар шүүж үзвэл бурханы лам хуваргууд байв. Олонх шарилд сэлмээр шархадсан шархны сорви хадгалагдан үлдсэн байгааг тэмдэглэжээ. Шинжилгээний ангийхан Идикутшарын ойролцоо өвөлжихөөр болсон байна. Судалгааны цаашдын явцад олон чухал баримт материалыг олсон байна. Тухайлбал А.фон Ле Кок эртний хотын зүүн хаалганы ойролцоох гишгүүртэй цамхагыг сонирхон судалсан байна. Түүний хөндий хонгилд урьд өмнө нь алталж будсан олон тооны бурхны хөшөө байрлаж байсан аж. Хотын туурийн бусад газруудаас энэтхэг цагаан толгойн үсгээр бичсэн бурхан шашны зохиолуудын тасархай олноор олдсон байна. Голын эсрэг талд байрласан жижигхэн байгууламж эрдэмтний анхааралд өртсөн бөгөөд тэр нь загалмайгаар чимэглэсэн тугийг гартаа барьсан морьтоныг дүрсэлсэн янз бүрийн ханын зургуудтай байжээ. Тэрхүү байшингийн ханан дахь хуучин зургуудыг будаггүй нэг жигд туйпуугаар өржээ. Түүний дараа сүүлчийн өрлөгийг авахад үндсэн ханан дээр бойпортой сүсэгтнийг дүрсэлсэн зураг харагдан, өөр жижиг гурван дүрсийг гартаа ногоон мөчиртэйгөөр дүрсэлсэн байна. А.фон Ле Кок уг зурагт троичуудын баярын өдрийг дүрсэлсэн байна гэсэн санал хэлжээ. Ханан дахь зургийн маяг нь өрнөдийн нөлөөг харуулж байгаа байгаа юм. А.фон Ле Кок нь эртний христосын сүмийн барилгын балгас байлгүй дээ хэмээн үнэндээ итгэсэн байна.³⁰ А.фон Ле Кок Тулюк-Мазар орох замдаа сүмийн нэгнээс бурханы хөргийн хэлтэрхий олдсон бөгөөд түүнийг зураач Т.Бартус туурганаас чадамгай салгасан байна. Малтлагын явцад өдөр алгасахгүй шахам зоос мөнгө олдож байсны дийлэнх олонх нь Хятадын Тан улс болон Персийн нэн эртний Сасанидынх байсан бөгөөд мөн торго болон хөвөн бөс бараа, олон хэлээр бичигдсэн гар бичмэлүүд ихээр олдсон ажээ. Идикутшарыг судлаад шинжилгээний анги хотын зүг Сенгим голын хавцал руу хөдөлжээ. Голын баруун эргээр нэгэн хэсэг бурхан сүмүүд байсан бөгөөд голын зүүн хэсгийн өндөрлөгүүдэд уур элбэг харагдаж байжээ. Бурханы тахилгад шатаасан

хүүрийн үлдэгдэл, хиймэл цэцгүүд, олон тооны гар бичмэл зэрэг олдсон байна. Голын баруун эрэгт ихэнх тохиолдолд түүхий туйпуугаар баригдсан сүмүүд байсан боловч агуй сүм ч байгааг шинжилгээний ангийхан илрүүлсэн байна. Эдгээр хийдийн цогцолборууд нь хүчирхэг бат бөх ханан хэрмээр хүрээлэгдсэн цамхагуудтай байжээ. Эрдэмтэд Сенгим голын эрэг дэх сүмээс хоёр номын сан илрүүлэн олсон ба бас тэгээд нэгэн номын санг том хийдэд нуусан байжээ. Зарим гар бичмэл нь шаргуу явдалтай үйдлийг тусгасан Майтрейтийн тухай шастирийн уйгур хэл дээрх тасархай болон тохар хэл дээр бичигдсэн зохиолууд байв. Эрдэмтэд нэгэн жижиг сүмд залгаж барьсан барилгын бурханы домгийг уйгур хэлэнд орчуулсан орчуулгын номын санг малтан гаргажээ. Заримдаа манейхейн болон бурханы брахми бичгийн гар бичмэлүүд мөн гарч иржээ. А.фон Ле Кок Сенгим голын хавцлыг судалсны дараа Безеклык руу мордсон ажээ. Энэ тосгоны зүүн хэсэг нь бусдаас илүү сайн хадгалагдсан бөгөөд тэнд нэг хэсэг нь газрын дээр байгуулагдсан агуйн хийд олджээ. Шинжилгээний ангийхан эхлээд газрын гадаргад байгаагаас нэгийг нь малтан судалсан байна. Гол барилгыг тойрсон хонгилыг элснээс цэвэрлэхэд хананаас нь сайн хадгалагдсан туургатны зураг олджээ.³¹ А фон Ле Кокын бичсэнээр Уйгурын хаант улсын үед зурагдсан эдгээр ханын зураг дээр нүүр царайг хэв загвараар биш аль болох биеийн байдлыг ойролцоо төстэй байхыг илүү эрхэмлэж байсан тодорхой байна гэжээ. Хонгилыг малтан цэвэрлэсэн шинжилгээний ангийн гишүүд тэндээс буддыг дүрсэлсэн 15 хөрөг зургийг олж авчээ. Үндэсний хувцастайгаар дүрсэлсэн тахилгачидын хөрөг нь онцгой үнэтэй олдвор байв.³² Төв байрны хаалганы баруун зүүн талаараа сүмийг үүсгэн байгуулагч эрэгтэй, эмэгтэй уйгурчуудын хөрөг дүрс байрласан ба хувцасласан байдлаас харахад язгууртан хүмүүс байна. Хөрөг дүрсийн ойролцоо уйгур бичгээр бичсэн бичээс хадгалагджээ. Туурганы зураг гурван эгнээгээр байрласан бололтой. Доод хэсгийн дүрслэл сайн хадгалагдсан ба тэнд “ван” ба “вангийн гүнж”-ийн дүрс онцгой товойн харагдах ажээ. Чиканголд мөн хэд хэдэн агуй эргийн ойролцоо эвдэрхий балгас олдсон байна. Тэндээс олон тооны эртний гар бичмэл олдсоны дотор буддын түүний (дотор дал модны навч ба хусны үйст бичсэн) манехейн, христосынх, мөн түрэг руни бичээсээр гар бичмэлийн тасархай, тэрчлэн жижигхэн модон нандин зүйлс, хатгамал зэрэг олджээ. Т.Бартус Сюйпан-Shyi-pang тосгоноос олон тооны гар бичмэлийг илрүүлэн олжээ. Түүний дотор нь түрэг хэлэнд орчуулсан ариун Георгийн тухай домог, балчир Христед шидтэн залран ирсэн тухай хуудам судрын орчуулга, евангелийн Матвейн тасархай, хатан хаан Еленд ариун Христос саатан морилсон домог гэх мэт христосын

агууламжтай бичээсүүд олджээ. Грек бичээсээр бичигдсэн нэгэн гар бичмэл олдсон ба тэр 9-р зуунд бичигдсэн огноотой байжээ.

Үргэлжлэл нь дараагийн дугаарт.

ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

17. Myller Friedrich Wilhelm Karl. Handschriften-Reste. "Manichaica": Bibliographie alttürkkischer Studien 2000. Harrassowitz Verlag. Wiesbaden. N. 10, 21-22, 31, 37, 53, 61, 73, 78, 88, 95, 100, 132, 155, 215-216, 440, 643, 727, 743
18. Johannes Benzig. Ein führung in das studium der altaischen Philologie and der Turkologie. Wiesbaden. 1953.
19. Doerfer G. und Tezcan S: Wörterbuch des Chaladsch. Budapest, 1980.
20. Gabain, Annemarie Von, (b. 7 April 1901, d. 15 January 1993; German scholar who worked in the field of Central Asian (primarily Turkic) studies, first as a linguist but later as an art historian. After completing a dissertation in Sinology, von Gabain studied Turcology with Johann Wilhelm Bang Kaup (q.v.), the founder of the Berlin school of Turkic studies, and she began to work on the Old Turkic materials kept at the Academy of Sciences in Berlin. She published the first grammar of Old Turkic in 1941. She also authored a general survey of "Irano-Turkish Relations in the late Sasanian Period" (*Camb. Hist. Iran* III/1, pp. 613-24). A third article (von Gabain, 1977) examined general aspects of the Irano-Turkic relationship and suggested a whole set of Turkic beliefs and customs going back to Iranian models; however, some of these ideas are no longer accepted, such as the theory (following Edward Conze) that the concept of the *bodhisattva* is of Iranian origin (von Gabain, 1977, p. 58). Von Gabain (1976) also provided the first extensive information about Old Turkic texts written in Sogdian script. These texts follow more strictly the scribal system used by the Sogdians themselves (the question of the orthography has been reviewed recently by Fedakbr, 1991, 1994) Works by von Gabain related to Central Asia studies: *Der Buddhismus in Zentralasien*, HO VIII/2, 1961, pp. 496-514. "Historisches aus den Turfan-Handschriften," *Acta Orientalia* 32, 1970, pp. 115-24. "The Purgatory of the Buddhist Uighurs: Book Illustrations from Turfan," in W. Watson, ed., *Mahayanist Art after A.D. 900, Colloquies on Art and Archeology in Asia* 2, London, 1972, pp. 25-35. "Kcitarbha-Kult in Zentralasien: Buchillustrationen aus den Turfan-Funden," in H.

- Härtel and V. Moeller, eds., Indologen-Tagung 1971, Wiesbaden, 1973, pp. 47-71. "Alt-türkische Texte in sogdischer Schrift," in *Hungaro-Turcica. Studies in Honour of Julius Nijmeth*, Budapest, 1976, pp. 69-77. "Iranische Elemente im zentral- und ostasiatischen Volksglauben," *Studia Orientalia* 47, 1977, pp. 57-70. *Einführung in die Zentralasienkunde*, Darmstadt, 1979. "Von Куиа (Kuan) nach Ввмиув: Eine kulturhistorische Studie," *Harvard Ukrainian Studies* III/4, 1979-80, pp. 258-70. "Irano-Turkish relations in the late Sasanian period," in *Camb. Hist. Iran* III/1, 1983, pp. 613-24. "Maitreya und Mithra," in W. Heissig and H.-J. Klimkeit, eds., *Synkretismus in den Religionen Zentralasiens*, Wiesbaden, 1987, pp. 23-32. "Die erste Generation der Forscher an den Turfan-Handschriften," in H. Klengel and W. Sundermann, eds., *Дгытн Vorderasien Turfan: Probleme der Edition und Bearbeitung altorientalischer Handschriften*, Berlin, 1991, pp. 98-105.
<http://www.iranica.com/articles/gabain-annemarie-von>
21. Bregel. Bibliography of Islamic Central Asia. East Turkestan pp.913-932
 22. Sh. Valichanov, *Sobranie soshinenii v 5-ti tomach*, A., 1961-1972. Adolf Schlagintweit (9 January 1829 - 26 August 1857) was a German explorer of Central Asia. Hermann, Adolf, and Robert travelled through the Deccan, then up into the Himalayas, Karakoram, and Kunlun mountains. While Hermann and Robert returned from their travels in early 1857, Adolf remained for further exploration, but with no trial was beheaded in Kashgar by Wali Khan, the amir of Kashgar, in August of that year as a suspected Chinese spy. The circumstances of his death were not known in Europe until 1859, when Chokan Valikhanov visited Kashgar disguised as a merchant and successfully returned back to Russian Empire.
 23. F. Richthofen, *Bemerkungen zu den Ergebnissen von Oberstleutnant Przewalski's Reise nach dem Lop nor und nach Altyn tagh*. Berlin., 1878. *China, Ergebnisse eigener Reisen und darauf gegründeter Studien*, Bb. 1-4, Berlin 1877-1883.
 24. A. Gr̄nwedel, *Bericht über archdologische Arbeiten in Idikutschari und Umgebung im Winter 1902-1903*, ABAM Bd. 24, 1905. s.3
 25. Albert Gr̄nwedel (* 31. Juli 1856 in M̄nchen; † 28. Oktober 1935 in Lenggries) war ein bekannter deutscher Indologe, Tibetologe und Archdologe, der zwei der vier deutschen

Gr̃nwedel war der Sohn eines Malers und studierte Kunstgeschichte und asiatische Sprachen, darunter Avestisch, bei Ernst Kuhn und Ernst Trupp. 1883 promovierte er an der Universit̃t M̃nchen. Bereits seit 1881 arbeitete er als Assistent am Museum f̃r Ṽlkerkunde in Berlin. 1883 wurde er zum stellvertretenden Direktor der ṽlkerkundlichen Sammlung und der skandinavischen Altert̃mer des Museums bef̃rdert. 1891 erhielt er f̃r seine zahlreichen Publikationen zur buddhistischen Kunst, Arch̃ologie Zentralasiens und den Sprachen des Himalaya eine Ehrenprofessur der Universit̃t Berlin. In seinen zwei Werken Buddhistische Kunst in Indien (1893) und Mythologie des Buddhismus in Tibet und der Mongolei (1900) wies Gr̃nwedel die griechischen Urspr̃nge der Kunst von Gandhara und ihrer Folgen in Zentralasien nach. 1899 wurde Gr̃nwedel von den russischen Orientalisten Radloff und Salemann eingeladen, an arch̃ologischen Forschungsexpeditionen im ñrdlichen East Turkestan teilzunehmen, wo bberreste alter Kulturen an der Seidenstrãe gefunden worden waren. Im selben Jahr wurde er zum Mitglied der Bayerischen Akademie der Wissenschaften gew̃hlt. Gr̃nwedel organisierte unter dem Eindruck der Forschungsarbeit seiner russischen Kollegen 1902–1903 selbst die erste deutsche Turfanexpedition, die vor allem in Idikutahri arbeitete. Die Ergebnisse beschrieb er in seinem Buch Bericht ̃ber arch̃ologische Arbeiten in Idikutschahri (1905). Die reiche Ausbeute dieser Expedition f̃hrte dazu, dass eine weitere Erkundungsmission – gef̃hrt von Albert von Le Coq – organisiert werden konnte. Gr̃nwedel selbst leitete auch die dritte deutsche Turfanexpedition, die 1905–1907 in Tumuq, Qaraahr und Turfan arbeitete. Die Ergebnisse dieser Expedition stellte er in dem Buch Altbuddhistische Kultst̃tten in Chinesisch-Turkistan (1912) dar. Im Vergleich zu seinem Kollegen Le Coq ging Gr̃nwedel behutsamer bei den Ausgrabungen vor, doch auch er liẽ ganze Fresken aus H̃hlenw̃nden herausmeĩeln und nach Europa verfrachten. Immerhin fotografierte er vor der Entfernung die Fundstellen und liẽ genaue Zeichnungen der Fresken anfertigen. Die Manuskripte, die er von seinen Expeditionen nach Deutschland brachte, sind bis heute schlechter dokumentiert als die f̃r die L̃ffentlichkeit viel spektakulreren Werke der bildenden K̃nste. Gr̃nwedel selbst nahm nicht an der Aufarbeitung der Manuskripte teil.

Gr̃nwedel war langjāhriges Mitglied der Berliner Gesellschaft f̃r Anthropologie, Ethnologie und Urgeschichte und wurde 1909 f̃r einen Vortrag ūber die archāologischen Ergebnisse der Turfan-Expedition mit deren Goldener Medaille geehrt. 1916 wurde er zum Geheimrat ernannt. Es kam zu Rivalitāten mit Le Coq und Wilhelm von Bode. Im Konflikt mit F. W. K. M̃ller ging es darum, wer als erster den Charakter der manchizischen Schrift und der in ihr verfassten Dokumente erkannt hatte. Es stellte sich heraus, dass M̃ller dieses Verdienst zukam.

1921 ging Gr̃nwedel in Rente und zog sich 1923 nach Bayern zur̃ck, wo er seine letzten Jahre in Lenggries bei Bad Tullz verbrachte und eine Reihe wissenschaftlicher Arbeiten verfasste. Beim Verfassen dieser Sp̃dtwerke war Gr̃nwedel durch eine sich verschlimmernde Krankheit beeintrāchtigt und unterschied nicht immer zwischen Realitāt und Illusion. Ernst Waldschmidt bemerkte, dass Gr̃nwedel schon bei einigen Passagen seines prachtvoll illustrierten Bandes *Alt-Kutscha* nicht zwischen Fakten, Spekulation und Erfindung unterscheidet. Dies trifft noch mehr f̃r sp̃ttere Werke wie *Die Teufel des Avesta*, *Die Legende des Na Ro Pa* und *Tusca* zu. In letzterem Buch behauptete Gr̃nwedel, das etruskische Problem gel̃st zu haben. Diese Sp̃dtwerke wurden von Forscherkollegen zwar scharf kritisiert, konnten jedoch nicht einfach ignoriert werden und erfreuten sich eines gewissen Einflusses. Gr̃nwedels Spekulationen ūber einen „etruskischen Satanskult“ beispielsweise wurden von Alfred Rosenberg in seinem Buch *Mythus des 20. Jahrhunderts* (M̃nchen 1930) ūbernommen.

- Buddhistische Kunst in Indien, 2. Auflage (Berlin 1920)
- Mythologie des Buddhismus in Tibet und der Mongolei: F̃hrer durch die lamaistischen Sammlungen des F̃rsten E. Ehtomskij (Leipzig 1900)
- Bericht ūber archāologische Arbeiten in Idikutschahri und Umgebung im Winter 1902-1903 (M̃nchen 1905)
- Altbuddhistische Kultstātten in Chinesisch-Turkistan (Berlin 1912)
- Alt-Kutscha: archāologische und religionsgeschichtliche Forschungen an Temperagemālden aus buddhistischen H̃hlen der ersten acht Jahrhunderte nach Christi Geburt. (Berlin, 1920).
- Die Teufel des Avesta und ihre Beziehungen zur Ikonographie des Buddhismus Zentral-Asiens (Berlin, 1924).
- Die Legende des Na Ro Pa, des Hauptvertreters des Nekromanten- und Hexentums: Nach einer alten tibetischen

- Handschrift als Beweis für die Beeinflussung des nördlichen Buddhismus durch die Geheimlehre der Manichäer, übersetzt von A. Grünwedel (Leipzig, 1933),
- Tusca (Leipzig, 1922)
26. A. Grünwedel, Bericht über archäologische Arbeiten in Idikutschari und Umgebung im Winter 1902-1903, ABAM Bd.24, 1905.
27. Albert von Le Coq (1860–1930) was a German archaeologist and explorer of Central Asia. He was heir to a sizable fortune derived from breweries and wineries scattered throughout Central and Eastern Europe, thus allowing him the luxury of travel and study at the - no longer existing - Museum für Völkerkunde in Berlin. Serving as assistant to the head of the Museum, Professor Albert Grünwedel, Le Coq helped plan and organize expeditions into the regions of western Asia, specifically areas near the Silk Road such as Gaochang. When Grünwedel fell ill before the departure of the second expedition, Le Coq was assigned to lead it. His account of the second and third German Turfan expeditions was published in English in 1928 as “Buried Treasures of Chinese Turkestan”. The expeditions found extensive networks of Buddhist and Manichaean cave temples in what is now north west China. Although many of the manuscripts found in the cave were destroyed during the excavation, von Le Coq speculated that he had discovered a major Manichaean library. Some of the paintings also led him to believe that he had found evidence of an “Aryan” culture, related to the Franks. With the help of his assistant Bartus, Le Coq carved and sawed away over 360 kilograms (or 305 cases) of artifacts, wall-carvings, and precious icons, which were subsequently shipped to the museum. In *Buried Treasures ...*, Le Coq explains these “borrowings” as a matter of necessity, citing the turbulent nature of Turkestan at the time of the expeditions. The artifacts were put on display at the museum and were open to the public until 1944 when, ironically, the museum suffered a direct hit in a British bombing raid, reducing the artifacts to rubble. Le Coq said that the depictions of figures with apparently blue eyes, red hair and cruciform swords resembled Frankish art: “Such more striking are representations of red-haired, blue-eyed men with faces of a pronounced European type. We connect these people with the Aryan language found in these parts in so many manuscripts.. These red haired

people wear suspenders from their belts. a remarkable ethnological peculiarity!

A.Le Coq . Die buddhistische Spätantike in Mittelasien, vol. 1: Die Plastik, Berlin: Dietrich Reimer, Auf Hellas Spuren in Ostturistan. Berichte und Abenteuer der II. Und III. Deutschen Turfan- Expedition, Leipzig 1926., Bildetratlas zur Kunst- und Kulturgeschichte Mittel-Asiens, Graz 1977.Chotscho, Graz 1979.A short account of the origin journey and results of the first Royal Prussian /second German/ expedition to Turfan in Chinese Turkistan, JRAS 4 /1909/Түркische Manichäica aus Chotscho, Bd.1-3.Berlin 1912-1922.Von Land und Leuten in Ostturkistan. Berichte und Abenteuer der IV Deutschen Turfanexpedition., Leipzig 1928.

28. A.Le Coq . Auf Hellas Spuren in Ostturistan. Berichte und Abenteuer der II. Und III. Deutschen Turfan- Expedition, Leipzig 1926.,s.43-44
29. A.Le Coq . Auf Hellas Spuren in Ostturistan. Berichte und Abenteuer der II. Und III. Deutschen Turfan- Expedition, Leipzig 1926.,s.47
30. A.Le Coq . Auf Hellas Spuren in Ostturistan. Berichte und Abenteuer der II. Und III. Deutschen Turfan- Expedition, Leipzig 1926., s.64
31. ibid s.73
32. ibid s.76